

## Байгалийн хий дамжуулах хоолой: Геополитикийн боломж ба сорилт

Пүрэвдоржийн Батжаргал

Доктор (Ph.D), Төвийн дарга, [batjargal@iss.gov.mn](mailto:batjargal@iss.gov.mn)  
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн  
Стратеги судалгааны хүрээлэн

### Хураангуй

Дэлхийн эдийн засаг тэлэхийн хэрээр эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж, улс орнууд газрын тос, байгалийн хийн нөөц, хэрэглэгчийн зах зээлээр дамжуулан нөлөөгөө тогтоохын төлөө өрсөлдөх боллоо. Газрын тос, байгалийн хийг нийлүүлэгч ба хэрэглэгч орнууд шууд хил залгаагүй тохиолдолд гуравдагч улсын нутаг дэвсгэр эсвэл далайгаар дамжуулан хоолой барьж, дамжин өнгөрөх орнуудын эрчим хүчний хэрэглээг хангах болсон. Энэ нь бүс нутгийн улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарлыг гүнзгийрүүлж, дамжуулах хоолойн геополитикийн ач холбогдлыг нэмэгдүүлэн, эрчим хүчний эх үүсвэрийн транзит тээврийн аюулгүй байдлын асуудлыг анхаарлын төвд оруулж байна.

XXI зуунд газрын тос, байгалийн хий дамжуулах хоолойн олон улсын мега байгууламжууд “эрчим хүчний геополитик”-ийн гол зэвсэг болж, улс орнуудын харилцан хамаарал, хүчний тэнцвэрийг тодорхойлох бас нэгэн хүчин зүйл боллоо. Эдгээр төслүүд нь бүс нутгийн тогтвортой байдал, том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөнтэй шууд холбоотой учраас манай улс энэ асуудлыг зөвхөн эдийн засаг, байгаль экологийн талаас нь бус үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын тэнцвэрийн үүднээс авч үзэх шаардлагатай юм.

**Түлхүүр үгс:** Эрчим хүчний геополитик, байгалийн хий, транзит хоолой

### Нэг. Байгалийн хий дамжуулах хоолой геополитиктой холбогдох нь

Бүс нутгийг хамарсан улс төр, эдийн засгийн хямрал, сөргөлдөөн үүсэхэд байгалийн хий дамжуулах транзит хоолойн геополитикийн ач холбогдол улам нэмэгдэж, энэ нь олон улсын аюулгүй байдлын эмзэг асуудал болох болов. Хямралын үед байгалийн хий нийлүүлэгч талаас давуу байдлаа геополитикийн хөшүүрэг болгон ашиглах оролдлого гаргаснаар зах зээлээ алдаж, дэд бүтэц нь үхмэл байдалд орж, эдийн засгийн үлэмж хохирол хүлээсэн гашуун туршлага ч байдаг. Мөн дамжуулагч буюу транзит тал “буруу тоглолт” хийвэл нийлүүлэгч болон хэрэглэгч талуудын цэрэг, улс төр, эдийн засгийн дарамт шахалтад орох, түрэмгийлэлд өртөх зэрэг аюул, эрсдэл тулгардаг байна.

### Хүснэгт 1. Олон улсын байгалийн хий дамжуулах хоолойн зарим томоохон төслийн геополитикийн ач холбогдол

д/д	Байгалийн хий дамжуулах хоолой	Дамжих улс	Хүчин чадал	Геополитикийн ач холбогдол
1.	Ямал-Европ	ОХУ-ын Баруун Сибирь, Ямалын хойгийн ордуудаас эх авч Беларусь, Польшоор дамжин Германд хүрдэг	2000 км гаруй урт, 32.9 тэрбум м <sup>3</sup> байгалийн хий дамжуулах хүчин чадалтай	Европ-Оросын эдийн засгийн хамтын ажиллагааны тулгуур, Оросын нөлөөллийг бэхжүүлэх эдийн засаг-дипломатын хэрэгсэл болж ирсэн. Дамжин өнгөрөх улсуудын, геополитикийн ач холбогдлыг нэмэгдүүлж, бодлогын хөшүүрэг нь болж байв. 2022 оны дөрөвдүгээр сард Польш өөрийн нутаг дахь дамжуулалтыг зогсоосноор энэ урсгал тасарсан.
2.	Уренгой-Помары-Ужгород (1984 онд ашиглалтад орсон)	Баруун хойд Сибирийн байгалийн хийг Украинаар дамжуулан Төв болон Баруун Европын орнуудад экспортолох зорилгоор Өрнөдийн санхүүжилт, технологийн оролцоотойгоор баригдсан	4451 км урт, оргил үедээ жилд 30 тэрбум м <sup>3</sup> -ээс дээш хий дамжуулж байв.	Өрнө-Дорнын хамтын ажиллагааны эерэг үзүүлэлт болсон тус хоолойгоор Хүйтэн дайны үед байгалийн хийг тээвэрлэхэд асуудал гарч байгаагүй. ЗХУ задарсны дараа Украины нутгаар дамжин өнгөрөх транзит тээвэрт төлбөрийн асуудал үүсэж, нийлүүлэлт тасалдаж эхэлсэн. Украины зүгээс эдийн засгийн ашиг сонирхлыг улс төртэй хослуулан ашигласан. Дайн эхэлснээр нийлүүлэлт зогссон.
3.	Умард урсгал-I	Оросоос Балтын тэнгисийн ёроолоор дамжуулан Герман болон Баруун Европын орнуудад байгалийн хийг нийлүүлдэг	1224 км урт, жилд 55 тэрбум м <sup>3</sup> хий дамжуулах хүчин чадалтай.	2011 онд баригдсан. Гуравдагч орны нутгаар дамжуулахад тулгардаг эрсдэл, сорилтыг бууруулсан. Украины дайн эхэлсний дараа Оросын тал нийлүүлэлтээ багасгаж, Европын орнуудад шахалт үзүүлэх хөшүүрэг болгосон. 2022 оны есдүгээр сарын 26-нд халдлагад өртөж зогссон.
4.	Умард урсгал-II	Оросоос Балтын тэнгисийн ёроолоор дамжуулан Герман болон Европын орнуудад байгалийн хийг нийлүүлдэг	1,230 км урт, жилд 55 тэрбум м <sup>3</sup> хий дамжуулах хүчин чадалтай.	2021 онд баригдаж дууссан. Европын эрчим хүчний аюулгүй байдал ОХУ-аас улам бүр хамааралтай болж, геополитикийн ач холбогдол нэмэгдсэн. 2022 оны есдүгээр сарын 26-нд халдлагад өртөж зогссон.

5.	Туркийн урсгал	ОХУ-ын Краснодарын хязгаараас Хар тэнгисийн ёроолоор дамжин Туркт хүрдэг, хоёр параллель шугам юм. Туркийн дотоодын хэрэглээ, Болгар, Серби, Унгар, Словак зэрэг Балканы болон Төв Европын орнуудад байгалийн хий нийлүүлэхэд чиглэгдсэн.	930 км урт, жилд 31.5 тэрбум м <sup>3</sup> хий дамжуулах хүчин чадалтай.	Гуравдагч орны нутгаар дамжуулах транзит хамаарал, эрсдэлийг бууруулсан. Турк бүс нутгийн байгалийн хийн зангилгаа (gas hub) болж чадсан. Украины дайн эхэлснээр “Туркийн урсгал”-ын ач холбогдол улам нэмэгдсэн.
6.	Азербайжан-Европын “Өмнөд коридор”	Өмнөд Европын орнуудад байгалийн хийг дамжуулах гол шугам. Гүрж, Турк, Грек, Албани, Италиар дамждаг.	3500 км урт, жилд 12 тэрбум м <sup>3</sup> хий дамжуулах хүчин чадалтай.	Харьцангуй олон орны нутгаар дамждаг, Европын орнуудын Оросоос байгалийн хийн хамааралтай байдлыг бууруулсан, цаашид Иран, Туркменистан, Ирак нийлүүлэлтэд нэгдэх боломжтой зэргээрээ геополитикийн өндөр ач холбогдолтой

Дээрх хүснэгтээс харахад нэгд, байгалийн хий дамжуулах хоолойн сүлжээ олон улсыг хамарч өргөжих тусам геополитикийн ач холбогдол нэмэгддэг; хоёрт, байгалийн хий хүлээн авагч буюу хэрэглэгч орнууд нэг улсаас эрчим хүчний хэт хамааралтай байх нь нийлүүлэгч болон дамжуулагч талуудын геополитикийн нөлөөлөлд автах эрсдэл дагуулаад зогсохгүй хямралын үед аюулгүй байдалд нь сөргөөр нөлөөлөх том хүчин зүйл болдог; гуравт, нийлүүлэгч болон дамжуулагч талууд байгалийн хий нийлүүлэлтийг тодорхой шалтгаанаар багасгах, тасалдуулах замаар эгзэгтэй үед геополитикийн хөшүүрэг болгон ашиглах зэрэг эрсдэлтэй нөхцөл үүсдэг байна.

Газрын тос, байгалийн хий дамжуулах транзит хоолойг геополитикийн хэрэгсэл болгон ашигласан сүүлийн үеийн жишээ нь Украины эргэн тойронд өрнөсөн үйл явдал болно. Хуучин ЗХУ-ын үед Европын орнуудад байгалийн хий дамжуулах зорилгоор баригдсан “Уренгой-Помары-Ужгород” хоолой болон газрын тос дамжуулах “Дружба” хоолойн Украины нутгаар дамжсан дэд бүтэц тус улсад “өвлөгдсөн” үлдсэн. Гэсэн ч Украины дотоодын улс төрийн тогтворгүй байдлаас шалтгаалан транзит хоолойг геополитикийн хөшүүрэг болгох гэсэн оролдлого удаа дараа гарч, дамжин өнгөрөх транзитын төлбөрийн асуудал байнга маргаан дагуулж, нийлүүлэлт тасалдах болсон. Иймд ОХУ-аас Европыг чиглэсэн Хөх, Туркийн урсгал байгалийн хийн урсгал Украиныг тойрох болсноор Киев геополитик, эдийн засгийн боломжоо алдахад хүрсэн байна.

Сүүлийн 80 гаруй жилийн туршид ОХУ Европын зах зээлд байгалийн хийн хамгийн том нийлүүлэгч байсан. Энэ нь Европыг эрчим хүчний хамааралтай байдалд оруулж, түүнийгээ улс төрийн хөшүүрэг болгон ашиглах геополитикийн давуу тал болж байв. Гэвч Украины дайнтай холбоотойгоор ЕХ-ны орнууд Оросоос байгалийн хийн хамааралтай байх нь геополитикийн өндөр эрсдэлтэй хэмээн үзэж, импортын хэмжээгээ шат дараатай бууруулж, 2027 оноос бүрмөсөн зогсоохоор шийдвэрлэсэн. Геополитикийн сөргөлдөөний улмаас дамжуулах хоолойгоор ЕХ-ны орнуудын импортолж байсан байгалийн хийн хэмжээ 2021 онтой харьцуулахад 2024 онд 42 хувиар буурчээ (Евсеева, 2025 №8(211)).

## Хүснэгт 2. Европын орнуудын 2021-2024 онд байгалийн хийн хоолойгоор авсан импортын хэмжээ (тэрбум м<sup>3</sup>)

Норвег		Орос		Алжир		Азербайжан		Бусад		Нийт	
2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024
113	119	167	51.4	34.1	29.3	19.5	24.4	23.4	8.1	369	232

Эх сурвалж: 2025 Energy Institute Statistical Review of World Energy

Ингэснээр ОХУ газрын тос, байгалийн хий нийлүүлэлтийн том зах зээлээ алдаж, эдийн засгийн хохирол амсаад зогсохгүй, геополитикийн давуу тал болж байсан хүч нь суларч байна. Харин Европын орнууд ОХУ-аас байгалийн хийн хэт хамааралтай байсан нь сөргөлдөөний үед сул тал болж, эрчим хүчний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн тул шинэ эх сурвалжаас харьцангуй өндөр үнэтэй шингэрүүлсэн байгалийн хий (Liquefied Natural Gas буюу LNG)-г худалдан авч байгаа.

ОХУ-аас Балтийн тэнгисийн ёроолоор дамжуулан Европын зах зээлд байгалийн хий нийлүүлж байсан “Умардын урсгал-1”, “Умардын урсгал-2” дамжуулах хоолойнуудыг 2022 оны есдүгээр сарын 26-нд дэлбэлснээс хэрэглэгч орнуудад эрчим хүчний хомсдол үүсэж, хэрэгцээгээ Америк, Катар, Алжир зэрэг орноос шингэрүүлсэн байгалийн хийгээр нөхөх хэрэгцээ үүссэн. “Умардын урсгал” дамжуулах хоолой дэлбэрснийг нэгд, Оросын дайныг санхүүжүүлдэг эх үүсвэрийн нэгийг таслах зорилготойгоор тусгай албадын зохион байгуулсан ажиллагаа; хоёрт, Европын зах зээлд шингэрүүлсэн байгалийн хий LNG нийлүүлж, улмаар эрчим хүчний хараат болгох зорилготой Америкийн геополитиктой холбоотой; гуравт, Европын орнуудад дарамт үзүүлэх зорилготой Оросын ажиллагаа байсан гэсэн таамаглалууд тухайн үед дэвшүүлж байв. Эндээс нэг дэх таамаглал бодитой байсан нь мөрдөн шалгалтын явцад тогтоогдсон байна. Мөн Словак, Унгар руу газрын тос дамжуулдаг “Дружба” хоолойн нийлүүлэлт 2026 оны нэгдүгээр сарын 27-нд халдлагын улмаас зогссон. Украины эрх баригчид энэхүү тасалдлыг Львов мужийн Броды хотын ойролцоо “Дружба” хоолойн байгууламжид Оросын нисгэгчгүй нисэх төхөөрөмж цохилт өгсөнтэй холбон тайлбарласан хэдий ч Унгар, Словакийн эрх

баригчид Украины санаатай үйлдэл хэмээн үзэж үйл ажиллагааг яаралтай сэргээхгүй бол Украин руу цахилгаан нийлүүлэлтээ зогсооно хэмээн мэдэгдэж байв. Европын Холбоо(ЕХ)-ны Украинд үзүүлэх зарим тусламжид Словак, Унгар улс хориг тавьж, ЕХ-нд элсүүлэхийг эсэргүүцэж байсан нь үүнтэй холбоотой байх магадлалтай. Энэ нь Украин газрын тосыг өөрийн нутгаар дамжуулдаг давуу байдлаа Словак, Унгарын эсрэг геополитикийн хөшүүрэг болгон ашиглах оролдлого хийж, үүний дүнд эдгээр орнууд хариу арга хэмжээ авсан байх магадлалтай.

Америк, Израил хамтран Ираны эсрэг цэргийн ажиллагааг 2026 оны хоёрдугаар сарын 28-нд явуулж эхэлсэнтэй холбоотойгоор дэлхийн зах зээлд газрын тос, байгалийн хийн нийлүүлэлтэд саатал гарснаас үнэ өсөж эхлэв. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2026 гуравдугаар сарын 04-нд “Европын зах зээлд нийлүүлдэг байгалийн хийн экспортыг бүрэн зогсоох” санаа илэрхийлсэн хэдий ч зах зээл дэх эрэлт өссөнтэй холбоотой хэрэв Европын Холбоо санал гаргавал дахин хамтран ажиллах боломжтой гэсэн мэдэгдэл хийсэн. Энэ нь Ойрх Дорнодын хурцадмал байдалтай холбоотойгоор Кремлийн зүгээс хийж буй геополитикийн том “нүүдэл” юм.

Товчоор дүгнэхэд, газрын тос, байгалийн хий дамжуулах олон улсын шинж чанартай транзит хоолой эдийн засгийн онолын хувьд тээврийн зардал багатай ч аюулгүй байдлын тал дээр геополитикийн өндөр эрсдэл дагуулдаг болохыг дээрх судалгаанаас харж болохоор байна.

### **Хоёр. ОХУ-аас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх “Сибирийн хүч-2” мега төсөл: Геополитикийн давуу ба сул тал**

Анх Орос, Хятад хоёр байгалийн хий дамжуулах хоолойг Монгол, Казахстаныг зааглах зурвас нутгаар тавих боломжийг судалж байжээ. Уг төслийг “Алтай” гэж нэрлэсэн байдаг. Энэхүү төслийг “Газпром” болон Хятадын Үндэсний газрын тос, байгалийн хийн корпорацын хооронд байгуулсан 2006 оны гуравдугаар сарын 28-ны өдөр протоколын дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөж байв (Порфирьев, № 11(401) 2007). Гэвч уг төсөл нэгдүгээрт, Хятадын баруун хойд буюу хүн ам сийрэг хэсэгт хүрэх бөгөөд тэндээс байгалийн хийн хэрэглээ өндөр төв ба зүүн хэсэг рүү тээвэрлэхэд зардал нэмэгдэх тул эдийн засгийн хувьд үр ашиггүй; хоёрдугаарт, Алтайн уулсын өндөрлөг газраар хийн хоолой барих техникийн хувьд амаргүй; гуравдугаарт, хий дамжуулах хоолой газар хөдлөлтийн идэвхтэй бүсээр дайрах тул эвдрэх, гэмтэх эрсдэлтэй; дөрөвдүгээрт, ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад багтсан Укокийн дархан цаазтай газар нутгаар дайран өнгөрөх учраас эсэргүүцэлтэй тулгарсан; тавдугаарт, улс төрийн хувьд тогтворгүй Шинжаан Уйгурын нутгаар дамжин өнгөрөх явдал эрсдэлтэй хэмээн үзэж цуцалжээ (Баттэлмэн, 2024 94/4).

Байгалийн хий дамжуулах “Сибирийн хүч-2” хоолой нь ОХУ-ын баруун Сибирь (Ямалын орд газрууд)-ийн байгалийн хийг Монгол Улсын нутгаар дамжуулан БНХАУ-д жилд 50 тэрбум (бүрэн хэмжээгээрээ ажиллаж эхэлмэгц) шоо метр хүртэлх байгалийн хий дамжуулах хүчин чадалтай мега төсөл юм. “Сибирийн хүч-2” хоолойн нийт урт нь 6700 км орчим бөгөөд үүнээс ОХУ-ын нутгаар ~2700 км, Монгол Улсын нутгаар 958.6 км үргэлжлэх юм. Хоолойн диаметр 1420 мм, ажиллах даралт 11.8 МПа орчим байх ба Монголын нутагт Алтанбулагаар орж, Сүхбаатар-Дархан-Улаанбаатар-Замын-Үүд гэсэн чиглэлээр төмөр замын дагуу тавигдахаар төлөвлөгдсөн байна. Монголын газар нутагт нийт таван компрессор станц, 2 үйлдвэрийн бааз, 1 хийн хэмжилтийн станц баригдахаар төлөвлөж буй бөгөөд барилгын ажлыг 2026 онд эхлүүлж, 4-5 жилийн хугацаанд үргэлжлүүлэн 2030 он гэхэд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” компанийн хооронд 2020 оны наймдугаар сарын 25-ны өдөр байгуулсан Эрмэлзлийн санамж бичгийн дагуу “Газпром” компанийн хөрөнгө оруулалттай тусгай зориулалтын компани болох “Газопровод Союз Восток” ХХК-ийг 2021 оны нэгдүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсад байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Тус компани нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Эрдэнэс Газ” төслийн нэгжийн дэмжлэгтэйгээр төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулан батлуулж, хийн хоолойн трассын дагуу иж бүрэн инженерийн хайгуул судалгааг гүйцэтгэж, нарийвчилсан зураг төслийн баримт бичгүүдийг боловсруулан магадалж, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж, Засгийн газрын зүгээс төслийн хүрээнд шаардлагатай газрын улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг бүрэн хангасан байна.

Улс төрийн түвшинд гурван улс төслийг хэрэгжүүлэх нэгдсэн зарчмын шийдвэрийг гаргасан боловч цаашид төслийг хэрэгжүүлэхээс өмнө бизнесийн, арилжааны нарийн нөхцөлүүдээ тохиролцох, Засгийн газар хоорондын гурван талт хэлэлцээрээр хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлэх ажлууд хүлээгдэж байна. “Газпром” болон “СНПС” компаниудын хооронд 2025 оны есдүгээр сарын 02-ны өдөр байгуулсан хууль эрх зүйн хариуцлага хүлээлгэх санамж бичигт, нэгдүгээрт, СНПС нь Монгол-Хятадын хил дээрээс жил бүр 50 тэрбум шоо метр байгалийн хийг худалдан авах 30 жилийн гэрээ байгуулах хүсэлтээ илэрхийлсэн; хоёрдугаарт, анхны байгалийн хийг 2031 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс дамжуулж эхлэхээр тохиролцжээ(Батгэлмэн, 2024 94/4). Мөн төслийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан тусгай зориулалтын компани болох “Газопровод Союз Восток” ХХК-ийн хувь эзэмшилд Хятадын талаас оролцох сонирхлоо илэрхийлж, Монголын талыг мөн оролцуулах шаардлага тавьж буйг “Газпром” компанийн зүгээс мэдээлсэн. Тус компанийн 51 хувийг “Газпром”, үлдсэн 49 хувийг Монгол, Хятад хоёр хоорондоо тохиролцон шийдвэрлэхээр тусгасан байна. Одоогоор төслийн нарийвчилсан нөхцөлүүд (төсөл хэрэгжүүлэгч компанийн хувь эзэмшил, төслийн санхүүжилт, дамжуулан тээвэрлэх тариф гэх мэт)-ийг эцэслэн тохиролцоогүй хэвээр, цаашид

шийдэх аж ахуйн нэгжийн түвшний арилжааны хэлэлцээ, төслийн хууль эрх зүйн баталгаа болох Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд хүлээгдэж байна.

2026 оны гуравдугаар сарын 04-12-ны өдрүүдэд болсон БНХАУ-ын ХИВ сонгуулийн БХАТИХ-ын дөрөв дэх чуулган болон УТЗЗ-ийн дөрөв дэх чуулган (“Хоёр чуулган” хэмээн нэрлэдэг)-аар баталсан XV таван жилийн төлөвлөгөөнд Сибирийн хүч-2 хоолойн урьдчилсан бэлтгэл ажлуудыг эрчимжүүлэхээр зааж өгсөн нь төсөл бодитоор хэрэгжих бас нэгэн баталгаа болов.

### **Талуудын геополитикийн ашиг сонирхол**

“Сибирийн хүч-2” төсөл нь Евроазийн эрчим хүчний газрын зурагт томоохон өөрчлөлт авчрах гүүр болно. Энэ нь ОХУ болон БНХАУ гэсэн хоёр том гүрний эрчим хүчний стратегийн огтлолцол дээр, гуравдагч орон болох Монгол Улсын нутаг дэвсгэрийг дамжин хэрэгжих учир геостратегийн ач холбогдлоороо онцгой юм. ОХУ, БНХАУ, АНУ болон Европын Холбоо зэрэг дэлхийн геополитикийг тодорхойлоход оролцдог хүчний төвүүд өөрсдийн ашиг сонирхлоос үүдэн энэхүү төслийг өөр өөр өнцгөөс харж байна.

**ОХУ-ын ашиг сонирхол:** Дайны байдалд буй ОХУ-ын хувьд Барууны хоригоос үүдэлтэй эдийн засгийн алдагдлаа нөхөхийн зэрэгцээ зах зээлээ тэлэхийн тулд байгалийн хийн экспортоо Зүүн Хойд Ази руу чиглүүлэн төрөлжүүлэх нь амин чухал ашиг сонирхол болоод байна. Оросын Европ руу чиглэсэн байгалийн хийн худалдаа огцом буурснаар асар их нөөцтэй Ямалын орд газрынхаа хийг Хятадын зах зээлд эргэлтэд оруулах шинэ гарц хайх болсон. Москвагийн байр сууринаас харахад “Сибирийн хүч-2” нь Евроазийн эрчим хүчний нийлүүлэлтийн сүлжээнд өөрийн байр сууриа нэмэгдүүлэх бодлогод нь нийцсэн, стратегийн түвшний ач холбогдолтой төсөл юм. Кремлийн хувьд Барууны орнуудад чиглэсэн экспортыг зүүн тийш чиглүүлж, энэ төслийг хэрэгжүүлснээр ОХУ, БНХАУ-ын эрчим хүчний уялдаа холбоо улам бэхжиж, эдийн засгийн харилцаагаа тэнцвэржүүлэх ашигтай. Мөн байгалийн хийн ашиглалт (хийжүүлэлт) сул хөгжсөн Сибирийн хот (Эрхүү, Улаан-Үд гэх мэт), тосгодыг энэ төсөлд бүрэн хамруулах давхар ач холбогдолтой.

**БНХАУ-ын ашиг сонирхол:** Бээжингийн зүгээс эрчим хүчний аюулгүй байдлаа хангах үүднээс импортын олон чиглэл, төрөлд тулгуурлах прагматик бодлого баримталдаг. Эрчим хүчний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зам, эх үүсвэрийг төрөлжүүлэх нь Хятадын хувьд аюулгүй байдлын чухал асуудал боловч одоогийн байдлаар гурван хоолойгоор байгалийн хий авч, бусад хэрэгцээгээ шингэрүүлсэн байгалийн хийгээр далайн боомтуудаар авч байгаа нь хангалтгүй юм. Далай боомтоор авч буй эрчим хүчний дийлэнх бүтээгдэхүүн АНУ болон түүний холбоотнуудын хяналтад байдаг Малаккийн хоолойгоор дамжиж байгаа нь цаашид Хятад, Америкийн тариф, худалдааны дайн дахин хурцадвал эрчим хүчний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдах, зогсох аюул өндөр юм. Мөн Ойрх Дорнодын тогтворгүй байдлын улмаас дэлхийн эрчим хүчний зах зээлд чухал

үүрэг гүйцэтгэдэг Ормузын хоолойгоор дамжуулан худалдан авдаг газрын тос, шингэрүүлсэн байгалийн хийн нийлүүлэлт цаашид тасалдах нь бодитой учир эх газрын дамжуулах хоолой Хятадын хувьд илүү найдвартай, аливаа эрсдэлээс хамгаалах нийлүүлэлтийн зам болж байна. Иймээс Америк, Катар зэрэг шингэрүүлсэн байгалийн хийн нийлүүлэгчдээс хэт хамааралтай байхгүйн тулд хуурай замаар дамжих хийн импортоо нэмэгдүүлж, эрчим хүчний төрөлжсөн зам маршрутыг сонгох стратеги баримталж байна. ОХУ-аас Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх хоолой нь БНХАУ-ын хувьд хамгийн дөт бөгөөд хүн ам ихтэй бүс нутагт шууд хүрэх эрчим хүчний баталгаатай, хямд эх үүсвэр болох тул ашиг сонирхолд нь бүрэн нийцэж буй юм.

**Барууны орнууд (АНУ, Европын Холбоо)-ын ашиг сонирхол:** Дэлхийн хамгийн их байгалийн хий үйлдвэрлэгч (2024 оны байдлаар 1 их наяд шоо метр орчим) (World Population Review, 2024) АНУ-ын хувьд Евроазийн зах зээлд аль болох их хэмжээний шингэрүүлсэн байгалийн хий нийлүүлж “эрчим хүчний ноёрхол” тогтоох стратеги, Хятад зэрэг өргөн хэрэглээтэй улс орныг Америкаас хамааралтай болгох геополитик баримталдаг. Тиймээс Оросоос Хятадад байгалийн хий нийлүүлэх хоолой тавигдаж байгаа нь Вашингтоны ашиг сонирхолд нийцэхгүй. “Сибирийн хүч-2” төсөл хэрэгжсэнээр Оросоос Хятадад нийлүүлэх байгалийн хий харьцангуй хямд үнэтэй орж ирэх тул Хятадын зах зээлээс Америкийн компаниуд шахагдах эрсдэл үүснэ. Үүнээс гадна ОХУ-БНХАУ-ын харилцаа улам бүр нягтрах нь АНУ-ын геополитикт мөн нийцэхгүй юм.

Европын Холбооны хувьд ОХУ-аас импортлох байгалийн хийн хэмжээ 2022 онд Орос-Украины дайн эхэлснээс хойш тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээ болон Оросын хийн хамаарлыг бууруулах бодлогын улмаас эрс буурсан. Энэ нь эрчим хүчний салбарт тодорхой хэмжээ эрсдэл үүсгэсэн боловч богино хугацаанд Америк, Алжир, Египет, Азербайжан, Норвег зэрэг өөр зах зээлээс нийлүүлэлтээ нөхөж чаджээ. Мөн 2030 он гэхэд хийн хэрэглээг бууруулах Төдийгүй Оросын хийн хамааралтай байдлаас урт хугацаандаа ангижрах стратегийг баримталдаг. Гэвч Оросоос Хятадад экспортлох байгалийн хийн үнэ Европын зах зээлийн үнээс бага байх тул Оросууд Европын зах зээлийг бүрэн орхиж чадахгүй гэсэн найдлага, “горьдлого” оршсоор байна.

**Монгол Улсын ашиг сонирхол:** “Сибирийн хүч-2” төсөл хэрэгжсэнээр Монгол Улсад эдийн засгийн шинэ боломжуудыг нээнэ (Баттэлмэн, 2024 94/4). Нэгдүгээрт, төслийн өртөг урьдчилсан тооцоогоор ~\$8 тэрбум ам.доллар байх учир гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн эдийн засаг тэлж, ДНБ-ий 7-8 хувийн хэмжээтэй мөнгөн урсгалыг бий болгоно. Хоёрдугаарт, төслийн бүтээн байгуулалт болон ашиглалтын үед хэдэн мянган шинэ ажлын байр бий болно. Гуравдугаарт, том төслийг дагаад дотоодын жижиг, дунд бизнес хөгжин төлөвшинө. Дөрөвдүгээрт, байгалийн хийг дотоодын хэрэгцээндээ ашиглавал (зөвхөн дамжуулагч бус мөн хэрэглэгч байх эсэхийг Монголын тал шийдвэрлэнэ) нийслэл болон аймгийн төвүүдийн агаарын бохирдлын асуудлыг бүрэн шийдвэрлэх

боломжтой болно. Цаашлаад аж үйлдвэрийг эрчимжүүлэх, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодит түлхэц болж, шинэ техник, технологи, инновац орж ирнэ гээд нийгэм, эдийн засгийг эрчимжүүлэх, илүү хурдасгах олон давуу талуудтай. Үүнээс гадна геополитикийн хувьд Монгол Улс анх удаа Евроазийн өндөр ач холбогдолтой эрчим хүчний нийлүүлэлтийн сүлжээнд холбогдож, ийм стратегийн төслийн нэг хэсэг болсноор хоёр хөршийн дунд өөрийн орон зай, оролцооны жинг нэмэгдүүлэх боломжтой. Том гүрнүүдийн дунд орших манай улс олон жил “гүүр улс” байх гадаад бодлого явуулж ирсэн бөгөөд энэхүү төсөл нь эрчим хүчний транзит гүүр болох замаар Монголын олон улсын харагдах байдал, оролцоог өргөжүүлэх давуу талтай гэж үзэж болно.

Монгол Улс энэ төслийн хүрээнд үүсэж болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллийг мөн бодолцох шаардлагатай. Хоёр том гүрнийг холбосон эрчим хүчний гүүр болох нь ашигтай боловч Монгол Улс өөрийн гадаад бодлогын бие даасан байдал, гуравдагч хөршүүдтэйгээ тэнцвэртэй харилцах зарчимд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. “Сибирийн хүч-2” хоолой нь геополитикийн боломж ба эмзэг байдлыг зэрэг авчрах тул том гүрнүүдийн дунд оршдог жижиг улсын хувьд Монголын оролцоог зөвхөн эдийн засаг, техникийн хэмжээсээр бус, харин геополитик, үндэсний аюулгүй байдлын үүднээс шинжлэх нь зүйтэй. Учир нь байгалийн хий нийлүүлэгч болон хүлээн авагч орнуудад геополитикийн өөрчлөлтийн аль ч үед дамжуулагч улс нь улс төрийн хувьд тогтвортой “найдвартай” байх нь маш чухал байдаг.

### *А/Үндэсний аюулгүй байдал сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл, сорилт*

“Сибирийн хүч-2” төсөл дээр дурдсанчлан манай улсын эдийн засаг, эрчим хүчний салбарт тодорхой үр ашиг, шинэ эх үүсвэр болох хэдий ч улс төр, аюулгүй байдлын урьд өмнө тулгарч байгаагүй шинэ эрсдэл, сорилтыг давхар дагуулна. “Сибирийн хүч-2” төсөл хэрэгжсэнээр манай улсын геополитикийн орчинд дараах эрсдэл, сорилт тулгарч болзошгүй юм. Үүнд:

- *Хоёр хөрш орноос хамааралтай байдал нэмэгдэх:* Транзит тээврийн аюулгүй байдал нь нийлүүлэгч ОХУ болон хэрэглэгч БНХАУ-ын хувьд маш эмзэг объект болох тул Монгол Улсыг улс төрийн хувьд тогтвортой, аль болох “дуулгавартай” байлгаж хий дамжуулах хоолойн аюулгүй байдлыг найдвартай хангахыг эрмэлзэнэ. ОХУ, БНХАУ-ын хэрэгцээтэй үед хөшүүрэг болгон ашиглах бодлогын улмаас эдийн засаг, эрчим хүчний дэд бүтцээрээ хоёр хөршөөс улам бүр хамааралтай болох магадлалтай.
- *Дотоод улс төр, аюулгүй байдлын эмзэг байдал:* Байгалийн хий дамжуулах хоолой нь олон зуун км үргэлжилсэн асар урт байгууламж тул дамжин өнгөрөх улсын дотоодод тогтворгүй байдал үүсвэл “маш эмзэг объект” болдог.
- *Байгалийн хийн ашиглалтыг нэвтрүүлснээс үүсэх эрсдэл:* Улаанбаатар хот болон төвийн бүсийн цахилгаан станцуудыг байгалийн хийд шилжүүлэх,

улмаар нүүрсний хэрэглээг бууруулах замаар утаа, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах давуу талтай боловч ОХУ-аас эрчим хүчний хамааралтай байдал хэвээр хадгалагдана.

**Б/ Монгол Улсад үзүүлэх давуу тал:**

- *Стратегийн хөшүүрэг нэмэгдэх:* Монгол Улс Евроазийн хамгийн том эрчим хүчний төслийн нэгэнд оролцсоноор Москва, Бээжинтэй тэнцвэртэй харилцах боломж нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл: манай улс транзит улсын хувиар бүс нутгийн эрчим хүчний урсгалыг тодорхой хэмжээнд хянах, чиглүүлэх чадвартай болж, энэ байр суурь нь цаашид хоёр хөрштэй харилцахад хөшүүрэг болгон ашиглах боломжтой. Жишээлбэл: Украин хийн хоолой дамжуулагчийн статусаа ашиглан Европт өөрийн байр суурийг нэмэгдүүлж чадсан байдаг. Монгол Улс эрчим хүчний тээвэрлэгчийн статустай болсноор “жижиг улс” гэхээс илүү олон улсын харилцаанд тэгш оролцогч байдлаар дуу хоолойгоо хүргэх боломжоо нэмэгдүүлэх юм. Ингэснээр Монгол Улс хөрш хоёр улстайгаа эн тэнцүү харилцах, нөлөөний тэнцвэрийг хангах бодлогоо хэрэгжүүлэхэд эергээр нөлөөлнө.
- *Эдийн засгийн шинэ тулгуур, төрөлжилт:* Хий дамжуулах хоолойн төсөл нь Монголын эдийн засгийг уул уурхай, мал аж ахуйгаас өөр шинэ салбар (эрчим хүчний тээвэр, химийн үйлдвэр г.м) руу тэлэх том боломж болно. Хоолойн хамгаалалт, барилга, засвар үйлчилгээ зэрэгт олон Монгол компани оролцож, шинэ ажлын байр олноор бий болно. Мөн хоолой дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд (зам, цахилгаан, холбоо г.м) хийгдэх тул зарим бүс нутагт хөгжил авчрах сайн талтай. Хоёр хөрштэйгөө зөвхөн уул уурхай, төмөр замын чиглэлээр хэт төвлөрч байсан хамтын ажиллагааг эрчим хүчний шинэ тулгуураар баяжуулж, Монгол Улс бүс нутгийн эрчим хүчний сүлжээнд өөрийн байр суурьтай болох юм.
- *Эрчим хүчний аюулгүй байдал, экологийн ашиг:* Байгалийн хий нь эрчим хүчний шинэ эх үүсвэр болж нэвтэрснээр Монгол Улсын эрчим хүч, байгаль экологийн аюулгүй байдалд эергээр нөлөөлнө. Хэрэв хий дамжуулах хоолойноос салбарлан дотооддоо хийн хангамжийн сүлжээ байгуулж чадвал Улаанбаатар хот болон төвийн бүсийн цахилгаан станцуудыг байгалийн хийд шилжүүлэх, улмаар нүүрсний хэрэглээг бууруулах замаар утаа, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах давуу талтай. Мөн хий ашиглан химийн үйлдвэр (азотын бордоо, метаноолоор шатахуун гаргах г.м) хөгжүүлэх боломж нээгдэнэ. Энэ бүхнийг амжилттай хэрэгжүүлбэл Монголын эдийн засаг нүүрснээс хамааралтай байдлаас

салах, эдийн засгийн шинэ бүтэцтэй болох ач холбогдолтой. Цаашлаад олон улсын түвшинд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйлсэд хувь нэмэр оруулж буй эерэг имиж бүрдүүлэх ба энэ нь гуравдагч хөршүүдээс өндөр үнэлгээ авах давуу тал болно (Парисын хэлэлцээрийн зорилтууддаа нийцэж байгаа гэх мэт).

### **Төслийн хэрэгжүүлэхийн өмнө баримтлах бодлого, стратеги**

- *Гэрээ, хэлэлцээрийн явцад үүсэж болзошгүй нөхцөлийг урьдчилан тооцох, Монгол Улсын эрх ашигт нийцсэн хууль эрх зүйн баталгааг бүрдүүлэх:* “Сибирийн хүч-2” төсөл олон улсын шинжтэй учраас талуудын хооронд хэд хэдэн түвшний гэрээ, хэлэлцээр байгуулагдана. Үүнд: ОХУ-БНХАУ хоёр улсын Засгийн газар хооронд хий худалдах-худалдан авах гэрээ (commercial contract), гурван улсын хоорондын Засгийн газар хоорондын хэлэлцээр (intergovernmental agreement), төслийн хэрэгжүүлэгч компанийн дотоод төслийн санхүүжилтийн гэх мэт шатлалтай гэрээ, хэлэлцээр байгуулагдах тул эдгээрт Монгол Улсын эрх ашиг, аюулгүй байдлын дархлааг сайтар тусгуулах ёстой. Тухайлбал: Засгийн газар хоорондын гурван талт хэлэлцээрт Монголын нутгаар хийг чөлөөтэй нэвтрүүлэх транзитын баталгаа, хоолойн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлын талаарх талуудын үүрэг хариуцлага, хилийн бүсэд ажиллах горим, татвар хураамжийн асуудлуудыг тодорхой тусгах шаардлагатай. Иймээс Монгол Улс холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүддээ байгалийн хий дамжуулах энэ хоолойн онцгой статусыг хэрхэн зохицуулахаа эхэлж тодорхой болгох шаардлагатай байна. Аливаа маргаан гарсан тохиолдолд олон улсын арбитраар шийдвэрлэх, хохирол гарвал нөхөн төлүүлэх, онцгой нөхцөл үүссэний улмаас тэвэрлэлт зогсоход авах арга хэмжээ гэх мэт заалтыг эрх зүйн баримт бичигтээ урьдчилан оруулж, улмаар Монголын эрх ашгийг хамгаалах эрх зүйн баталгаа бүрдүүлэх нь маш чухал юм. Төслийг тойрсон хэлэлцээрүүдийг судлах мэргэжлийн баг ажиллуулж, нухацтай хандах нь зүйтэй юм.
- *Эдийн засгийн үр өгөөжийг баталгаажуулах:* ОХУ, БНХАУ-ын хооронд үнэ, хөрөнгө оруулалтын хэлэлцээр явагдаж буй энэ үед Монгол Улс өөрийн хүртэх үр өгөөжийг урьдчилан тооцож, гурван талт хэлэлцээний явцад баримтлах байр сууриа тооцсон хэд хэдэн хувилбар боловсруулсан байх шаардлагатай.
- *Нийгэмд ил тод, нээлттэй мэдээлэл хүргэх:* Монгол Улсад гадаадын (ялангуяа “гуравдагч хөрш” гэгддэг орнуудын) хөрөнгө оруулалттай мега төсөл хэрэгжүүлэх явцад олон нийтийн сүлжээ ашиглан элдэв сөрөг мэдээлэл цацах, улмаар иргэдийг эсэргүүцэлд турхирах үзэгдэл нийтлэг байдаг. Энэ төслөөс үлэмж хэмжээний ашиг хүртэнэ гэсэн буруу ойлголт нийгэмд хэдийнээ бий болсон нь төслийн талаар бодит мэдээлэлгүй улс

төрчид, мэргэжлийн бус эрдэмтэн судлаачид олон нийтэд үндэслэлгүй мэдээлэл өгч байгаатай холбоотой. Иймд эдийн засгийн ашиг, байгаль экологийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх талаар бодит мэдээлэл нийгэмд өгөх нь зүйтэй юм.

- *Төсөлд хөрөнгө оруулах:* Монголын тал энэ мега төсөлд хөрөнгө оруулж хувь эзэмшсэнээр хяналт тавих, ногдол ашиг хүртэх давуу талтай. Энэ талаар одоогоос ОХУ, БНХАУ-ын талуудтай ойлголцолд хүрэх нь чухал. Монголын тал бололцооныхоо хэрээр хөрөнгө оруулалтад оролцож, түүнийхээ хэрээр үр ашгаа хүртэх зарчим баримтлах нь манай ашиг сонирхолд нийцнэ.
- *Аюулгүй байдлыг хангах асуудлыг урьдчилан тооцох:* Байгалийн хий дамжуулах хоолой нь Монгол Улсын стратегийн ач холбогдолтой дэд бүтэц болох учир төрөөс тусгай хамгаалалтад авах, аюулгүй байдлын төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Хоолойн хамгаалалтыг Монголын тал хариуцахаар (Баттэлмэн, 2024 94/4) байна. Олон улсын эрх зүйн дагуу энэхүү хоолойн аюулгүй байдлыг гурван тал хамтран хангах заалт оруулах (жишээ нь, террорист халдлага гарвал гурван тал хамтран мөрдөн шалгах, мэдээлэл солилцох механизм г.м) талаар ч хэлэлцэж болно. Ялангуяа кибер аюулгүй байдлын үүднээс хяналтын системийг хамгаалах, осол аваарын үед гурван талын шуурхай хороо ажиллуулах гэх мэт нарийн зохицуулалтууд ч хэрэгтэй.

### Дүгнэлт

Байгалийн хий дамжуулах хоолой нь зөвхөн эдийн засгийн мега төсөл биш, харин эрчим хүчний аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдал, улс хоорондын харилцан хамаарал, геополитикийн өрсөлдөөнийг тодорхойлогч хүчин зүйл юм. ХХI зууны олон улсын харилцаанд байгалийн хий дамжуулах хоолойн геополитикийн ач холбогдол улам бүр нэмэгдэж байна.

“Сибирийн хүч-2” мега төсөл үүний нэг тод илрэл болж, Евроазийн эрчим хүчний зураглалыг өөрчлөхүйц нөлөө үзүүлэх юм. ОХУ-аас Европт алдаж буй байр сууриа нөхөхөөр Зүүн зүгт эрчим хүчний том гүүр барьж, БНХАУ урт хугацааны хийн хангамжаа баталгаажуулах шинэ эх үүсвэртэй болж буй энэ нөхцөлд Монгол Улс уг төслийн төвд оролцох болсноор геополитикийн боломжоос гадна эрсдэл, сорилт ч мөн тулгарна. Гэвч “Сибирийн хүч-2” төслийн манай улсын хөгжил, аюулгүй байдалд үзүүлэх эерэг нөлөө нь сөрөг нөлөөнөөс илүү юм. Хий дамжуулах хоолой Монголын геополитикийн ач холбогдлыг нэмэгдүүлж, бүс нутгийн тоглолтод оролцох орон зайг тэлэх, эдийн засгийн шинэ эх үүсвэртэй болох эерэг нөлөөтэй.

### Эх сурвалжийн жагсаалт

Евсеева.О.”Влияние геополитического кризиса на мировой газовый рынок и перспективы развития российской газовой отрасли”. “Энергетическая политика”. №8(211).2025

Баттэлмэн Б. “Байгалийн хий дамжуулах хоолойн транзит”. Стратегийн судалгаа 94/4. УБ., 2024. т.145

Ralf Dickel, Cross-Border Oil and Gas Pipeline Projects: Analysis and Case Studies, the World Bank, review version, 5 September 2001

Paul Stevens, “Pipelines or Pipe Dreams? Lessons from the History of Arab Transit Pipelines,” Middle East Journal, spring 2000, pp. 224–241

ESMAP, *Cross Border Oil and Gas Pipelines: Problems and Perspectives* (Washington, D.C.: UNDP/WB, 2003).

Миронова И. “Российский газ в Китае: Сложные вопросы на переговорах по трансграничным трубопроводам” доклад в Секретариате Энергетической Хартии. 2010.т17

Порфирьев, Б. Н. Оценка рисков проекта газопровода из России в Китай. ЭКО.2007. № 11(401). т79-93. EDN IBTOTX.

---

## Natural Gas Pipelines: Geopolitic Opportunities And Challenges

**Batjargal Purevdorj**

Doctor (Ph.D), Head of Center, [batjargal@iss.gov.mn](mailto:batjargal@iss.gov.mn)

The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

### **Abstract**

*As the global economy expands and energy consumption increases, geopolitical competition for influence over oil and gas resources and their consumer markets is intensifying. Therefore, pipelines designed to transport oil and natural gas reliably and cheaply from areas with significant reserves to major consumers have become increasingly important. In cases where natural gas suppliers and consumers do not share direct borders, oil and natural gas are transported through pipelines laid across third countries or across the sea. Since gas pipelines provide energy to a certain part of a country or several countries, connecting many countries in the region economically and deepening their interdependence, transit security is a very sensitive issue for both supplier and consumer countries. These factors increase the geopolitical importance of gas pipelines. This article analyzes the geopolitical advantages, as well as the risks and challenges that international pipelines for transporting natural gas pose to supplier, transporter, and consumer countries, based on specific facts.*

**Keywords:** *Energy geopolitics, natural gas, transit pipelines*